

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК 2018 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/2/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: Б.Эрдэнэтунгалаг
Утас: 99063931 Цахим хаяг: sain.audit5831@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.07 № 1-6/2858
танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД НААҮ ОНӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ө.НАРАНТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Замын-Үүд НААҮ ОНӨХХК –ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд НААҮ ОНӨХХК –ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланматериаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд НААҮ ОНӨХХК –ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

444190292

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд НААҮ ОНӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ө.Нарантуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 28-наас 2019 оны 03 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 11-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сайн Аудит ХХК-ын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 32 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК нь Замын-Үүд сумыг цэвэр цэмцгэр байлгаж ард иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ариутгал цэвэрлэгээний үйл ажиллагаа
- Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж
- Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- ААНОАТатварын тухай хууль
- НДШимтгэлийн тухай хууль
- ХХОАТатварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төв талбайн авто зогсоолын орлогыг сумын ИТХ -ын шийдвэрээр 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 100% захиран зарцуулах эрхийг тус байгууллага олгосон. байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Leader” програм хангамж ашигладаг байна.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тайлант үед алдагдалтай ажилласантай холбоотой юм.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2018 оны нийт зардал 943160,4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 9431,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дундаж хувьтай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 6 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.00	

2.9. Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК нь 2018 онд төсвөөс 496.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 307.7 сая төгрөг олж нийт 804.4 сая төгрөгийн орлоготой ажилласан. Тайлант үеийн 146.9 сая төгрөгийн алдагдал нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой юм.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Саналд үгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Замын-Үүд НААҮ ОНӨ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Зарим албан томилолтын мөнгийг захирлын цохолтгүй, тооцоо бодсон тэмдэглэлгүй ажилласан газрын тамга тэмдгийг үндэслэн олгосон байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББүртгэлийн тухай хуулийн 13.5.д **“Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”** гэснийг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээ хийх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ажилчдад томилолтыг олгохдоо захирлаар зөвшөөрсөн цохолт хийлгэж, нягтлан бодогч тооцоог бодсон бичилт хийсний дараа олгож байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиров.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Ажилчдад цалингийн урьдчилгааг их бага хэмжээгээр касснаас зарим саруудад 2-3 удаа олгож байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1-д **.Ажилтны цалин хөлсийг сард хоёр удаа, тогтоосон өдөр олгоно** гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Ажилчдын цалинг илүү дутуу тооцох

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн урьдчилгааг ажилчдад сар болгоны тогтсон нэг өдөр нэгдсэн журмаар олгож байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиров

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад (2019,06,30)-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Огноо: 2019.03.11

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2018.01.01	2018.12.31
А.Хөрөнгө		
1.Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	87,959,721.59	146,498,443.97
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
Дансны авлага	-	-
Бусад авлага	974,464.00	974,464.00
Татвар, НДШ-ийн авлага	-	-
Бараа материал	12,248,623.99	7,525,010.30
Эргэлтийн хөрөнгийн дүн	101,182,809.58	154,997,918.27
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	3,096,458,278.00	2,823,706,310.00
Биет бус хөрөнгө	900,000.00	450,000.00
Бусад биет бус хөрөнгө /газар/		99,875,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,097,358,278.00	2,924,031,310.00
Нийт хөрөнгийн дүн	3,198,541,087.58	3,079,029,228.27
Өр төлбөр ба эздийн өмч		
Дансны өглөг	3,675,812.00	2,214,000.00
Цалингийн өглөг		801,360.00
Татварын өр	30,998,858.70	37,335,084.50
Банкны богино хугацаат зээл	-	2,700,885.96
Богино хугацаат өглөгийн дүн	34,674,670.70	43,051,330.46
Урт хугацаат зээл		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-
Нийт өр төлбөрийн дүн	34,674,670.70	43,051,330.46
ӨМЧ: а) төрийн	4,020,911,851.00	4,039,977,493.00
б) хувийн		
Нэмж төлөгдсөн капитал	277,420,366.00	277,420,366.00
Хуримтлагдсан ашиг	(1,134,465,800.12)	(1,281,419,961.19)
Эздийн өмчийн дүн	3,163,866,416.88	3,035,977,897.81
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	3,198,541,087.58	3,079,029,228.27

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>ҮЗҮҮЛЭЛТ</i>	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны орлого	725,466,121.18	744,493,659.87
Борлуулалтын өртөг	0.00	
Нийт ашиг/алдагдал/	725,466,121.18	744,493,659.87
Хүүний орлого	0.00	3,039,824.07
Бусад орлого	8,235,520.36	10,395,035.00
Ерөнхий ба удирдлагын зардал	899,846,024.56	892,389,382.60
Санхүүгийн зардал	274,600.00	164,416.41
Бусад зардал	7,731,858.00	12,328,881.00
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-174,150,841.02	-146,954,161.07
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг	-174,150,841.02	-146,954,161.07

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Огноо: 2019.03.11

Үзүүлэлт	/төгрөгөөр /	
	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	795,970,047.98	815,837,033.40
Борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний орлого	789,811,907.98	307,798,513.87
Татаас санхүүжилтийн орлого		496,762,429.00
бусад орлого	6,158,140.00	11,276,090.53
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	666,459,948.00	723,237,786.50
Ажиллагчдад олгосон мөнгө	335,473,662.00	362,676,632.00
Нийгмйн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	80,640,135.00	77,449,720.85
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	129,289,211.00	146,281,453.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	19,018,593.00	34,873,783.00
Түлш шатахуун , тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	31,214,603.00	19,498,832.00
Төлсөн хүү	-	
Татварын байгууллагад төлсөн	61,254,227.00	64,979,763.00
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,685,500.00	
Бусад мөнгөн зарлага	7,884,017.00	17,477,602.65
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	129,510,099.98	92,599,246.90
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,749,983.61	700,848.17
Мөнгөн орлогын дүн		
Хүлээн авсан хүүний орлого	5,749,983.61	700,848.17
Мөнгөн зарлагын дүн	119,348,790.00	34,550,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	114,683,790.00	34,550,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд	4,665,000.00	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(113,598,806.39)	-33,849,151.83
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	-	30,000,000.00
Банкнаас авсан зээл, үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	30,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	-	30,211,372.69
Зээлийн төлөлт		30,211,372.69
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-211,372.69
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	15911293.59	58,538,722.38
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72048428.00	87,959,721.59
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	87959721.59	146,498,443.97

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

д/д	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	4,020,911,851.00	277,420,366.00	-	3,163,866,416.88
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт /	44,942,427.00			44,942,427.00
3	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт /				
4	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц				
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
6	Тайлант үеийн цэвэр ашиг			-146,954,161.07	-146,954,161.07
7	Өмчид гарсан өөрчлөлт	-25,876,785.00			-25,876,785.00
8	Гаргасан хувьцаат капитал				0.00
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,039,977,493.00	277,420,366.00	-	3,035,977,897.81